




ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт






ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2020 онд: **+6.1%**  
Инфляци: 2020 онд: **7.5%**

Урсгал тэнцэл: 2020 онд: **-13%**-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2019 оны тайланд тоймлосон байна.

ДНБ-ий өсөлт: 2020 онд: **+6.3%**  
Инфляци: 2020 онд: **+7.1%**


ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2020 онд: **-10.8%**- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2019 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <http://bit.ly/2zsmvYo>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

**Төсвийн тэнцэл 2-р сарын байдлаар 120 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.**

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 79.3 хувиар, зарлага 150.7 хувиар тус тус нэмэгдсэн бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 29.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 120 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.




**Ам.долларын ханш өмнөх сараас 12 төгрөгөөр өсөв.**

Хоёрдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 123 төгрөг буюу 4.7 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 12 төгрөг буюу 0.4 хувиар, өмнөх улирлаас 1.8 хувиар өсч 2756.50 төгрөг болов. 2-р сард гадаад валютын нөөц 4.3 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 0.22 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 20.7 хувиар, оны эхнээс 0.5 хувиар тус тус өсөв.




**Инфляцийн түвшин 6.4%**

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2020 оны 2-р сарын байдлаар өмнөх сараас 1.2 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 6.4 хувиар, оны эхнээс 2.1 хувь өсөв. Ингэж өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундаа, хувцас, бөс бараа, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний өссөн нь голлон нөлөөлжээ.




**Гадаад худалдааны тэнцэл 20.7 сая.ам доллар болов.**

2020 оны хоёрдугаар сард нийт барааны эргэлт 1520 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 16.9 хувиар буурсан бол экспорт өмнөх сараас 29.5, импорт өмнөх оны мөн үеэс 10 хувиар тус тус буурч гадаад худалдааны тэнцэл 20.7 сая ам.долларын ашигтай гарчээ.



## 2-Р САРЫН ОНЦЛОХ: ДНБ

Эх сурвалж: [www.1212.mn](http://www.1212.mn)

ДНБ 2019 оны 4-р улирлын байдлаар (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 9.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 18,958 тэрбум төгрөгөөр нэмэгдэж эдийн засгийн өсөлт 5.1 хувиар өсөв. Хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 2.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 8.4 хувиар өссөн нь ДНБ-ий 5.1 хувийн өсөлтийн 1.1 пунктийг бүрдүүлсэн байна. ДНБ-д 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр эцсийн хэрэглээ 67.3 хувь, хөрөнгийн нийт хуримтлал 35.8 хувь, цэвэр экспорт (-3.1) хувийг эзэлж, өмнөх оноос эцсийн хэрэглээ 1.3 пунктээр, цэвэр экспорт 2.5 пунктээр нэмэгдэж, хөрөнгийн нийт хуримтлал 3.8 пунктээр буурчээ. Статистикийн хорооны тооцооноос харахад өнгөрсөн оны мөн үед эдийн засгийн өсөлт (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 5.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 386.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж эдийн засгийн өсөлт 6.9% болсон.

## САРЫН ОНЦЛОХ

## ДЭЛХИЙН БАНКНЫ МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ ТАЙЛАНД

- Дэлхийн банкнаас энэ 2 дугаар сард гаргасан Монгол Улсын эдийн засгийн тойм тайланг танилцуулав. Харин 2020-2021 онд хувийн хэрэглээний тогтвортой өсөлт, уул уурхай, аж үйлдвэрлэлийн салбарын хөрөнгө оруулалтын нөлөөгөөр эдийн засаг дунджаар 5.6 хувиар өсөх төлөвтэй байна. Гэвч гадаад болон дотоод орчны тодорхойгүй байдал нэмэгдэж байгаагаас эдийн засгийн хэтийн төлөвт эрсдэл нэмэгдэж байна. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн хэтийн төлөв нь ирэх 2020 оны сонгуулиас үүдсэн улс төрийн тодорхойгүй байдал, АНУ болон БНХАУ-ын худалдааны хэлэлцээрийн тодорхой бус байдал шинэ төрлийн коронавирусуунаас БНХАУ-ын эдийн засагт үзүүлэх нөлөө нь Монголын эдийн засагт сөргөөр нөлөөлөх төлөвтэй байна.

## УУЛ УУРХАЙ ОЛБОРЛОХ, АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР 2-Р САРД

- Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн энэ оны эхний саруудад өмнөх оны мөн үеийнхээс 524.4 (43.9%) тэрбум төгрөгөөр буурчээ. Үүнд нүүрсний борлуулалт 245.6 (51.7%) тэрбум төгрөгөөр, газрын тосны борлуулалт 25.2 (35.2%) тэрбум төгрөгөөр, хүдрийн борлуулалт 253 (40.0%) тэрбум төгрөгөөр, бусад ашигт малтмалын борлуулалт 542.6 (3.7%) сая төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлжээ. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүний 557 тэрбум төгрөг буюу 83.2 хувийг гадаад зах зээлд борлуулжээ. Гадаад зах зээлд борлуулсан уул уурхайн бүтээгдэхүүний 53.9 хувийг металлын хүдэр, 35.8 хувийг нүүрс, 8.3 хувийг газрын тос, 2.0 хувийг бусад ашигт малтмал олборлолтын салбарын бүтээгдэхүүн эзэлж байна.

Эх сурвалж:

- Статистикийн бюллетень, 2-р сар 2020 он, Үндэсний статистикийн хороо
- Статистикийн бюллетень, 2-р сар 2020 он, Монголбанк
- [www.1212.mn](http://www.1212.mn), [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn), [www.montsame.mn](http://www.montsame.mn)